

**АФГАНИСТАН – УУЛЫНХАНЫ УЛС***Л.Бэгзжав\**

Исламын Бүгд Найрамдах Афганистан Улс (The Islamic Republic of Afghanistan) нь Азийн баруун өмнөд хэсэгт, хойгуураа Туркменистан (744 км), Узбекистан (137 км), Тажикстан (1206 км), баруунаараа Иран (936 км), өмнө ба зүүн талаараа Пакистан (243 км), зүүн хойгуураа Хятадын Синьзянтай (76 км) хиллэн оршдог (хилийн нийт урт 5599 км) эх газрын улс юм. Афган улс 652.300 км<sup>2</sup> газар нутагтай, 2007 оны 7-р сарын байдлаар, 31.889.923 хүн амтай, хүн амын 44.6% нь 0-14 насны хүүхэд, дундаж наслалт 43.7 байна.<sup>1</sup> Афганистан улсын геополитикийн байрлал нь олон улсын харилцааны анхаарал татсан халуун цэгийн нэг байсаар ирсэн.

Афган гэдэг үгийн гарвалыг хөөвөл эртний перс хэлэнд “уулан дээрх хүн” гэсэн утгатай аж. Афганы газар нутгийн 54% нь уулархаг буюу өндөрлөг, нутгийн талаас илүү нь далайн түвшингээс дээш 2000 м өндөрт оршиж, эртнээс хүн амын дийлэнх уулархаг нутагт амьдардагаас эртний персүүд тэднийг уулынхан, улсыг нь уулынханы орон гэдэг байв.

Афган гэдэг үгэнд перс хэлний “стан” улс гэдэг үгийг нэмж Афганистан буюу Афган улс гэх болжээ. Дашрамд тэмдэглэхэд, Афган + стан буюу Афган улс гэж дэлхий нийтээр нэршсэн байхад бид Афган улс + улс хэмээн нэрлэж буйг анхаарч засмаар санагдана. Тухайлбал Туркмен улс, Узбек улс, Тажик улс гэх мэт нэрлэж болно. Улс орон бүр өөр өөрийнхөө бичиг үсэг, хэл зүйн дүрэмд нийцүүлэн улс орны нэршлийг бичиж занших учиртай, оросоор “Объединенные Арабские Эмираты” гэж хэлдэг байхад манайх Арабын Нэгдсэн Эмират Улс гэх нь зөв байтал, гадаад харилцааны аль ч түвшинд Эмират улс гэж буруу бичих нь ердийн зүйл болжээ. Энэ бол ганц нэг үг үсгийн төдий зүйл бишээ.

Афган хэмээх үгийн гарлыг эртний нэг Эмирийн нэр Afghana буюу Ховройн (еврей) хаан Шароны ач хүү Афганы нэрээс гаралтай ч гэж үздэг.

Эртний Ромын үеийн түүхчдийн бүтээлд Афганчуудыг Assakani буюу Asskeni гэдэг байсан нь морин цэрэг гэсэн утгатай бөгөөд улсын нэр нь “хүчлэн дайрч, ялан дийлэх” гэсэн<sup>2</sup> утгатай гэж тэмдэглэсэн байдаг аж. Хятадын “Вэйшү” (“Вэй улсын судар”), “Сүй шү” (“Сүй улсын судар”), “Вэйши” (“Умартын түүх”) зэрэг эртний сурвалж бичгүүдэд Афганыг tu huo lu (Tu kha ra), da ueshi буюу uezhi гэж тэмдэглэсэн байдаг. Энэ нь эртний Хятадын Хань улсын (МЭӨ 206-МЭ 220 он) баруун хязгаарын улсыг uezhi гэдэг байснаас үүдэлтэй. Эдгээр ном зохиолд афганчуудыг Хүннүгийн үед Монгол нутгаас их нүүдэл хийж, одоогийн газартаа нутагшсан гэж дурдсан нь бий.<sup>3</sup>

\* Л.Бэгзжав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Олон үндэстний орон Афган нь 30 гаруй их бага үндэстэнтэй. Хүн амын дотор пушту 42%, тажик 27%, хазар, узбек тус бүр 9%, аймак 4%, туркмен 3%, валоч 2% үндэстэн эзэлдэгээс гадна киргиз, чурамак зэрэг олон үндэстэн бий. Албан ёсны хэл нь пушту, дари (перс) хэл хэдий ч узбек, турк, киргиз зэрэг олон хэлээр ярилцдаг байна. Шашин шүтлэгийн хувьд хүн амын 98% нь исламын шашин шүтдэгээс 90% нь суннит урсгал, үлдсэн нь шиит урсгал шүтдэг аж.

XIII зуунаас Афганд суурьшсан монголчууд мянгатын зохион байгуулалтаа он удаан жилээр хадгалж байсаны учир хазарууд буюу мянгатынхан гэж нэрлэгдэх болжээ. Хазар гэдэг нь тажик зэрэг хэлээр мянгат гэсэн үг болой. Хазаруудыг холимог угсаатай гэдэг. Судлаачдын тогтоосноор тэдний 90% нь монгол цустай, 5% нь турк, үлдсэн нь бусад үндэстний холыц аж.<sup>4</sup> Дэлхийн монгол угсаатанд тооцогддог хазарууд Афганд 4-5 сая орчим бий гэсэн баримт байдаг<sup>5</sup> агаад хазаруудын могол хэл нь алтай язгуурын хэлний бүлэгт багтана гэж хэл шинжлэлчид үздэг.

Түүх сөхвөл, МЭӨ ҮI зуунд Персийн Ахеминидын эзэнт улсын бүрэлдэхүүнд анх Афганистан гэж дурдагдаж, түүхийн он жилүүдэд удаа дараа Грек, Энэтхэг, Ираны хаадын ноёрхолд байжээ. МЭ ҮIII зууны үед Арабууд эзлэж, 1220 онд Чингис хааны цэргүүд Афганыг эзэлтэл хамгийн хүчтэй нөлөөтэй байжээ. Тус орон ХIҮ зуун хүртэл Монголчуудын засаглалын доор байсныг нарийвчлан судлаж, Монголын түүхийн шинжлэх ухаанд тодорхой тусгах хэрэгтэй байна.

ХҮII зууны үеэс уугуул афганчуудын хүч өсч, 1747 онд Персийн ноёрхлыг унагаж “зууны сувд эрдэнэ” гэж алдаршсан Эмир Ахмад Шахын толгойлсон Афганы анхны төр улс үүсч байжээ. Гэвч энэхүү Эмирт улс задран, нэгдэж явсаар ХIХ-ХХ зуунд Англи улсын түрэмгийлэлд удаа дараа өртөж байсан ч 1919 онд Афганы ард түмэн Английн 3 дахь удаагийн түрэмгийллийг таслан зогсоож тусгаар тогтнолоо мөн оны 8-р сарын 19-нд зарласан билээ.

Афганистан улс 1919-1973 он хүртэл хаант засагтай байсан юм. 1973 оноос хойш тус оронд улс төрийн хүчин олонтаа солигдож, төрийн дэглэм хэдэнтээ халагдаж, 1992 онд одоогийн Афганистаны Исламын Бүгд Найрамдах Улс болсон юм. 1979 онд тус оронд хуучин ЗХУ-ын цэрэг орж, 1989 онд гарсан хэдий боловч тэр цагаас хойш өдгөө хүртэл дайны байдал байна.

Дэлхийг цочоосон “9-р сарын 11”-ний (2001) хэрэг явдлаас хойш АНУ тэргүүтэй олон улсын терроризмын эсрэг цохилтонд Афганы Талибаны засгийн эрх нурж, 2001 оны эцсээр Афганистанд засаг төрийн шинэ цаг үе бий болсон ч улс орны байдал хүнд хэцүү хэвээр дайны дараах сэргээн босголтын ажил үргэлжилсээр байна. Дайны галаас дайжиж 6 сая гаруй хүн Пакистан, Иран, Дундад Азийн орнуудад зугтан гарчээ.<sup>6</sup> 2001

оны 11-12-р сард НҮБ-ын удирдлага дор Бонны хурал хуралдаж, Афганы холбогдох бүлэглэлүүдийн хооронд яриа хэлэлцээ хийж, Афганы түр засгийн газар байгуулж, мөн оны 12-р сарын 22-ноос албан ёсоор бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлэв. 2002 оны 6-р сард Кабулд Их Жиргагийн (парламент) хуралдаан болж сүүлийн 20 гаруй жилд анх удаа яриа хэлэлцээр, хүч хэрэглэлгүй улс орныхоо асуудлыг шийджээ. Улсын ерөнхийлөгчөөр пушту үндэстний удирдагч Хамид Карзайг сонгосон байна. 200 орчим эмэгтэй төлөөлөгч оролцсон уг Жирга нь түүхэнд анх удаа афган эмэгтэй хүн эрчүүдтэй хамт улс төрийн хэргийг шийдэж, улс төрд орсон содон шинэ зүйл байв.

Афган нь олон жил дайны хөлд нэрвэгдсэн хоцрогдсон хөдөө аж ахуйн орон юм. Тус орны хүн амын 40% нь ажилгүй (2005), 53% нь ядуу зүдүү (2003) байдалд аж төрж байгаа ба хууль бус хар тамхины бизнес 3 тэрбум долларт хүрч, тариалангийн 48%-д буюу 107.400 га талбайд хууль бус мансууруулах ургамал тариалж байгаа нь<sup>7</sup> дэлхий нийтийн санааг зовоож байна. Афганы засгийн газар төсвийн тогтвортой байдал, ажлын байр нэмэгдүүлэх, авилгатай тэмцэх, засгийн газрын чадавхийг дээшлүүлэх, дайнд нэрвэгдсэн дэд бүтцийг сэргээн босгохыг урт хугацааны зорилт болгон ажиллаж байна. Энэ зорилгоор гадаадын орнуудаас 24 тэрбум долларын тусламж авах аж.<sup>8</sup> Афганд цэвэр усны нөөц бага, усан хангамж муу, хөрсний эвдрэл их, түлшинд их хэрэглэж буйн улмаас ойн нөөц багассан, агаарын болон усны бохирдол ихэссэн зэрэг байгаль экологийн ноцтой асуудал тулгарсаар байна. Эх газрын хуурай уур амьсгалтай, хур бороо багатай, өвөлдөө хахир хүйтэн, зундаа аагим халуун тус орны эдийн засгийн гол тулгуур нь хөдөө аж ахуй, бөгөөд хүн амын 80% нь энэ салбарт ажиллаж, үндэсний нийт бүтээгдэхүүний 70-аас дээш хувь, экспортын 80 орчим хувийг үйлдвэрлэдэг. Буудай, эрдэнэ шиш, арвай, тутарга, хар тамхи голчлон тариалдаг. Хонь, ямаа, үхэр, илжиг, луус, адуу, тэмээ өсгөдөг.

Аж үйлдвэрийн хувьд гар аргаар гол төлөв боловсруулдаг. Уул уурхайн салбар нь бааз суурь муу, техник технологи хуучирсан, гадаадын хөрөнгө оруулалтанд найдлага тавьдаг юм. Хэдийгээр Афган ашигт малтмалын ихээхэн нөөцтэй боловч тээвэрлэлтийн бэрхшээл, хөрөнгө мөнгөний гачаалаас болж нүүрс, давс, номин, байгалийн хий, хром зэргийг л олзворлож ашигладаг. Байгалийн хийн нөөц нь 150 тэрбум шоо метр, нүүрснийх нь 400 сая тонн аж.<sup>9</sup>

Нийслэл Кабул хот эртнээс дорно өрнийн худалдааны “торгон зам”-аар нэвтрэх гол хотын нэг байсан. Энэтхэг хийгээд олон орны соёлын ул мөр Афганд гүн ул мөрөө үлдээсэн юм. Гэвч өнөөгийн Афганы соёл гэгээрийн үйлс нэн хоцрогдож, Дэлхийн Банкны гаргасан мэдээгээр хүн амын 64,9% нь бичиг үсэг огт мэддэггүй, эмэгтэйчүүдийн дөнгөж 20,1% нь бичиг үсэг мэддэг аж.<sup>10</sup>

2002 оны 3-р сарын 23-нд Афганд бараг 3000 сургууль албан ёсоор хичээлийн шинэ жилээ эхлэж, дунд бага сургуулийн 1.5 сая сурагч хичээлийн жилийн нээлтийн ёслолд оролцсон байна. Энэ арга хэмжээнд зориулж НҮБ-аас 22 сая ам.доллар зарцуулж багш нарын цалинг олгож, сурагчдад хичээлийн сурах бичиг, ном дэвтэр өгч тусалжээ.<sup>11</sup> Бага сургууль нь 3 жилийн сургалттай бөгөөд Афганы сургуулиудын бараг тал хувь нь дайн самууны уршгаар эвдэж нурсан учир сурагчид хээр задгай газар, сандал ширээ ч үгүй завилан сууж хичээлэх нь олонтаа аж.

Афганы ард түмний ёс заншил нэн өвөрмөц, хүн амын ихэнх нь хөдөө тосгонд амьдардаг, амьдрал ахуй нь хоцрогдмол, бөглүү тусгаарлагдмал, амьдралын хэв маяг, зан заншил нь шашин болоод овог аймаг, гэр бүлийн нөлөөнд их автагдсан ажээ. Иргэд нь бараг цөмөөр исламын шашин шүтдэг тул гэр орон, сүм хийд, олон нийтийн газар, тэр ч байтугай цэргийн ангид хүртэл хаана л бол хаана цаг минут бүр мөргөл үйлдэнэ. Афганд овог аймаг, гэр бүл, цусан төрлийн холбоо нийгэмд чухал байр эзэлдэг. Уламжлалт гэр бүлийн байдал нь хэдэн үеэрээ нэг том гэр бүлд хамт амьдрах ба эцэг эх нь гэрийн эзэн, ууган хүү нь тэдний хууль ёсны залгамж болдог. Гэрлэлтийг эцэг эх нь зохицуулна, бүл садангийн улс хоорондоо гэрлэх нь уламжлалаар хамгийн сайн гэрлэлтэнд тооцогдоно, гэр бүл салж болохгүй, гол нь тогтвортой амьдрах ёстой. Ислам шашны номоор бол нэг эр 4 эхнэр авч болох авч энэ ёс одоо алдагдаж байгаа аж.<sup>12</sup> Афганд эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурь доор, тэд нийгмийн үйл ажиллагаанд оролцож болохгүй, сонгогдох эрхгүй, улс төр, шашин, гэр бүлийн хатуу дарамт, хүлээсэнд байдаг.

Хэдийгээр Афганы ард түмэн наадан баясах, үндэсний дуу бүжигтээ дуртай ч гэлээ эрэгтэй эмэгтэй хоёр хамт бүжиглэж, хамт дуулж, жүжиглэж болохгүй. Гэр бүлийн харилцаа бол нийгэмд хүмүүсийн хоорондын үндсэн харилцаа ба нэгэн их гэр бүлд хамгийн настай эрэгтэй хүн хамгийн том удирдагч байна. Гэр бүл болгон өөр өөрсдийгөө хангаж өөрсдийгөө болгож байдаг бичил нийгэм юм. Эмэгтэйчүүд сурч болохгүй, гэрээсээ гадна өөр эрчүүдийн өмнө гивлүүрээ сөхөж болохгүй, гадаадад явж болохгүй гэх мэт олон бичигдээгүй хууль нийгэмд үйлчилдэг. Цусан өшөө авах явдал Афганд үеэс үед уламжилсан уламжлалт, харгис ял шийтгэлийн зарчим юм.

Афганы гол баяр ёслол нь нийтийн он тооллын 3-р сарын 21, Афганы тооллын 1-р сарын 1-нд болдог Наурызын баяр. Энэ баярыг улсын хэмжээнд 15 өдөр тэмдэглэж, хүмүүс төрөл садан, найз нөхөддөө мэндчилгээ хүргэж, зарим газар урлаг соёлын арга хэмжээ болдог байна. Улсын баяраа 4-р сарын 28-нд, тусгаар тогтнолын баяраа 8-р сарын 19-нд тэмдэглэдэг.

Монгол Улс Афганистантай 1962 оны 2-р сарын 1-нд дипломат харилцаа тогтоосон бөгөөд 1983 оны 7-р сард хоёр орны хооронд Найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулснаар Монгол, Афганы ард түмний найрамдал, хамтын ажиллагаа өргөжин хөгжиж байв. Одоо Афганистан дахь сэргээн босголтын ажилд НҮБ-ын Энхийг сахиулах хүчний эгнээнд мөр зэрэгцэн яваа монгол цэргүүд идэвхитэй оролцож, үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

### ЭШЛЭЛ

1. <http://www.cia.gov/library/publications/the-world-factbook/print/af.html>
2. zhang zhongxiang. Shijie geguo guoming jijing. Бээжин 1987, 4-р тал
3. “Ням гариг” сонин. 1998.01.18, №3 (202)
4. “Өнөөдөр” сонин. 2002.01.14
5. “Өнөөдөр сонин. 2002.01.17
6. “Shijie zhishi huabao”. 2002. №231. 32-37-р тал.
7. <http://www.cia.gov/library/publications/the-world-factbook/print/af.html>
8. <http://www.cia.gov/library/publications/the-world-factbook/print/af.html>
9. geguo gaikuang (ya zhou). Бээжин. 2000.07-р сар. 36-р тал
10. мөн тэнд
11. “Shijie zhishi huabao” сэтгүүл. 2002. 9-р сар. 35-р тал
12. zhongguo zhoubian gaikuan. Бээжин. 1994. 286-р тал.